



АВТО ЗОГСООЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д газар ашиглалтын зөв хуваарилалтыг бий болгох, хот төлөвлөлтөд орон зайн зөв шийдэл бүхий авто зогсоолыг хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж, уг харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, авто зогсоол байгуулах, ашиглах, эзэмших, түүнд тавигдах шаардлага, аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлыг нарийвчлан тодорхойлох зорилгоор Авто зогсоолын тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгагдсан.

Улсын Их Хурлын 2010 оны “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай” 36 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 1.6-д “Авто зогсоолын тухай хуулийн төслийг шинээр боловсруулж батлах” гэж, Монгол Улсын Их Хурлын 2014 оны “Ногоон хөгжлийн бодлого батлах тухай” 43 дугаар тогтоолын хавсралтын 3.6.6-д “Явган зорчигчийн зорчих хэсэг, ногоон байгууламж, дугуйн зам, зогсоолын төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгож явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны “Монгол Улсын Засгийн газрын “2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 45 дугаар тогтоолын хавсралтын 2.99-д “Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорх болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ.” гэж заасан.

1.2.Практик үндэслэл, шаардлага:

Монгол Улсын хэмжээнд 2014 оны байдлаар тээврийн хэрэгслийн тоо нийт 618744 байсан бол 2015 онд 720278, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 894016 хүрсэн байна. Үүнээс зөвхөн Улаанбаатар хотод 2014 онд нийт 385090 тээврийн хэрэгсэл байсан бол 2015 онд 439129, 2017 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 508459 байна. Ийнхүү автотээврийн хэрэгслийн тоо жил ирэх тутам өсч байгаа нь нийслэл хотын авто замын даац, чанар болон иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл болон хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж байна.

Замын хөдөлгөөний ачааллыг бууруулахад чиглэсэн гол арга хэмжээнүүдэд гудамж, зам, талбайн төлөвлөлтийг хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цогц төлөвлөлтийн систем бий болгохоос гадна зогсоолын менежмент ба төлбөртэй зогсоолын арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай. Авто зогсоолын тоо хангалтгүй, зогсоолын талбай төлөвлөгдөөгүй байгаа нь хотын өнгө үзэмжийг дордуулж, авто машины түгжрэл, замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг үр дагавар үүсгэх шалтгаан болж байна.

Хот, суурин газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон авто замын төлөвлөлттэй уялдаагүй, хөдөлгөөний аюулгүй байдлын стандартын шаардлага хангаагүй, зориулалтын бус газарт автотээврийн хэрэгслийн зогсоол барьж байгуулан үндэслэлгүйгээр харилцан адилгүй төлбөр тогтоож байгаа асуудлыг зохицуулах шаардлагатай байна.

Авто тээврийн хэрэгслийн зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарц, тэмдэглэгээ гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даасан байдлыг хангах зэргээр үйлчилгээ үзүүлэх, авто замын хөдөлгөөнд саадгүй оролцох нөхцөлийг хангах талаар холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага авто зогсоол байгуулах, авто зогсоолын орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөшүүргийг бий болгох мөн авто зогсоолын мэдээллийн сангийн нэгдсэн тогтолцоог бий болгох, нэвтрүүлэх шаардлагатай.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 4/ 27 дугаар тогтоолоор “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 175 дугаар тогтоолоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд авто зогсоол төлөвлөх, барьж байгуулах журам”-ыг тус тус батлан мөрдүүлж байна. Мөн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Авто замын тухай хууль нь авто зогсоол, түүнтэй холбогдолтой асуудлуудыг зохицуулаагүй, зөвхөн зам, замын байгууламжтай холбоотой асуудлыг зохицуулж байна. Иймд замын хөдөлгөөний ачааллыг багасгах, явган зорчигч буюу иргэдийг хот, сууринд тав, тухтай амьдрах нөхцөлийг хангасан, олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн авто зогсоолын асуудлыг тусгайлан хуулиар зохицуулах нь зүйтэй байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлох талаар

Авто зогсоолын тухай хуулийн төслөөр дараахь харилцааг зохицуулна. Үүнд:

Авто зогсоолын талаарх нэр томъёог тодорхойлон авто зогсоол байгуулах, хөгжүүлэхэд баримтлах зарчим болон авто зогсоолыг нийгмийн хэрэгцээ, ашиглалтын шаардлагад нийцсэн хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан, батлагдсан зураг төслийн дагуу техник, технологийн дэвшлийг ашиглан төлөвлөж байгуулах талаар тусгана.

Авто зогсоолын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тусгахаас гадна авто зогсоол байгуулах үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан бүсчлэл, замын ачааллын тооцоо, судалгааны үндсэн дээр авто зогсоол төлөвлөн байгуулах, олон улсад өргөн хэрэглэгдэж буй мэдээллийн цахим сүлжээнд суурилагдсан төхөөрөмж бүхий автоматжуулсан болон механикжсан

авто зогсоол байгуулах, тэдгээрийн чанар, стандартын шаардлага хангахад чиглэсэн норм, нормативын баримт бичиг бий болгох, авто зогсоол төлөвлөх, байгуулах, ашиглалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангахтай холбогдсон үйл ажиллагааг тусгана.

Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, нутаг дэвсгэрийн бүсчлэл, газар зохион байгуулалт, хүн амын тоо зэргээс хамааруулан авто зогсоолын эрэлт, хэрэгцээний судалгаа хийх, авто зогсоолын хомсдол бүхий нутаг дэвсгэр, замын хөдөлгөөний хэвийн байдлыг алдагдуулж буй авто зогсоолыг тодорхойлон, авто зогсоол шинээр бий болгох, авто зогсоолын орчны нөхцөлийг сайжруулах, авто зогсоолыг төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх үе шатны төсөл, хөтөлбөр боловсруулах, авто зогсоол барих боломжтой газрын байршил, хэмжээг тогтоож, шаардлагатай хөрөнгийн урьдчилсан тооцоог боловсруулах, энэ талаар олон нийтэд мэдээллэх ажлыг тухайн шатны Засаг даргад даалгах, шинээр барих барилга, байгууламжийн зураг төсөлд тухайн орон нутгийн хот, суурины төлөвлөлт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, авто зогсоолын эрэлт, хэрэгцээтэй уялдуулан холбогдох хууль тогтоомжид заасны дагуу авто зогсоолыг төлөвлөх, авто зогсоолын төрөл, ангилал, ерөнхий бүтэц, шаардлага болон төхөөрөмж бүхий авто зогсоолын тоног төхөөрөмж, тэмдэг, тэмдэглэгээнд тавигдах стандарт, зориулалтын талбай, барилга, байгууламжийн норм, дүрмийг боловсруулж мөрдүүлэхээр тусгана.

Авто зогсоолын төрөл, ангиллаас хамааруулан авто зогсоол байгуулах, тэдгээрт тавигдах шаардлага, авто зогсоол барьж байгуулах, арчлан хамгаалах, авто зогсоолын үйлчилгээний төлбөр, түүний хэмжээг тогтоох, түүнтэй холбоотой дүрэм, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн хэм хэмжээг тухайн орон нутгийн засаг захиргаанд бүрдүүлж өгөх асуудлуудыг тусгана.

Авто зогсоолын төлбөр, хураамж тэдгээрийн хэмжээ, төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, үйлчилгээ эрхлэх журам тогтоох субъект, төлбөртэй зогсоолд тавигдах шаардлагын талаар тусгана.

Авто зогсоолын төрөл, ангилал, зориулалт, өмчийн хэлбэрээс хамааруулан авто зогсоол байгуулах, арчлан хамгаалахад шаардлагатай санхүүжилтийн асуудал, авто зогсоолын барилга, байгууламж, авто зогсоолын тоног төхөөрөмж, тэмдэг, тэмдэглэгээний хяналттай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Энэхүү хуулийн төслийг боловсруулж баталснаар дараахь үр дүнд хүрнэ. Үүнд:

1.Монгол Улсын Үндсэн хуульд заасан “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх”- ийг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

2.Авто машины зогсоол байгуулах газар, тэдгээрийн төлөвлөлт, авто зогсоолын ангилал, төрөл, тавигдах шаардлага ба авто зогсоолын зөвшөөрөл, төлбөр, иргэн, хуулийн этгээдийн хоорондын харилцааг зохицуулан энэхүү харилцаанд оролцогч этгээдүүдийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлж авто зогсоол байгуулахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийг дэмжсэн тогтолцоо бий болно.

3.Газар ашиглалтын зөв хуваарилалт бий болж, хот төлөвлөлтөнд орон зайн зөв шийдэл бүхий, автотээврийн хэрэгслийн зогсоолыг тухайн хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж бий болгох эрх зүйн орчин бүрдэнэ.

4.Иргэд өөрийн эд хөрөнгийн аюулгүй байдлыг ханган хот, суурины замын сүлжээг сайжруулах, даац нэвтрүүлэх чадамжийг нэмэгдүүлэн хөдөлгөөний нягтрал буурах нөхцөл бүрдэнэ.

5.Авто замын хөдөлгөөний төлөвлөлт, хяналт, зохион байгуулалт орчин үеийн шаардлагын хэмжээнд ойртож, агаарын бохирдолд тээврийн хэрэгслээс үзүүлэх нөлөөлөл буурна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа бөгөөд Хот байгуулалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай, Авто замын тухай, Автотээврийн тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Шуудангийн тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

---oOo---